



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.06 № 03/2074
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зарласан НХААГ/20240102630 дугаартай "Эмнэлгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Хүрээ амаржих газар)" нийлүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	Амбулаторийн шинжилгээ авах ширээ /хаалттай/ 3 хэсэгтэй байх цахилгаан тэжээл хангамж холбох хэсэгтэй байх Техникийн тодорхойлолтод барааны тоо хэмжээг 4 ширхэг гэж заасан байна. Энэ нь 3 хэсэгтэй 4 ширхэг гэхээр нийтдээ 12 шинжилгээ авах ширээ гэж ойлгох нь зөв үү? Үүний тоо ширхгээс хамаараад тендерт санал болгох үнэ өөрчлөгдөх тул тоо ширхгийг тодорхой болгож	Шинжилгээ авах ширээ нь 4 ширхэг болно. Цахилгаан тэжээлийн хангамж холболтыг 3 хэсэгтэй байх гэж заасан болно.
2	Лабораторийн ширээ Хэмжээ: 160х, 120, 90, 80х хэмжээтэй байх 2 угаалтууртай. Тендерийн техникийн тодорхойлолтод 4 өөр хэмжээ бичсэн байгаа тул лабораторийн ширээний урт, өндөр, өргөний хэмжээг нарийн тодруулж өгнө үү. Тендерийн техникийн тодорхойлолтод ширээний тоог 2, угаалтуурын тоо мөн 2 гэж заасан байна. Энэ нь ширээ тус бүр 1 угаалтууртай гэж ойлгох нь зөв үү? Нэг ширээнд байрлах угаалтуурын тоог тодруулж өгнө үү. Тендерийн техникийн тодорхойлолтод заасан ширээ нь залгууртай байх уу? Нэг ширээнд байх залгуурын тоог тодруулж өгнө.	160 дунд талын тавиур орсон өндрийн хэмжээ, 120 урт, 90 өргөн, 80 ширээний өндрийн хэмжээ болно. Нэг ширээ нь 2 угаалтууртай байна. Ширээ нь залгууртай байх бөгөөд 1 оролт бүхий олон залгууртай байж болно.
3	Лабораторийн ширээ 180х, 129, 90, 80х хэмжээтэй байх Хананд тогтоох тавиуртай 2 хаалгатай Тендерийн техникийн тодорхойлолтод 4 өөр хэмжээ бичсэн байгаа тул лабораторийн ширээний урт, өндөр, өргөний хэмжээг нарийн тодруулж өгнө үү.Тендерийн техникийн тодорхойлолтод заасан тавиурын урт,	180 дээд талын ханын шүүгээ орсон нийт өндөр, 129 урт, 90 өргөн, 80 ширээний өндрийн хэмжээ болно. 129 урт, 90 өргөн, 80 өндөр Ханын тавиур нь ширээний хэмжээтэй

өндөр, өргөний хэмжээг нарийн тодруулж өгнө үү.

дүйцэхүйц хэмжээтэй байна.
(Зураг харах)

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.